



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/294

Булган сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 30 дугаар зүйлийн 30.1, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Засгийн газрын 2024 оны 136 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн 6 дугаар цэцэрлэг (РД:9012753)-т Булган сум 5 дугаар баг Хатанбаатар С.Магсаржав 1 дүгээр гудамж 121а тоотод байршилтай 1100 м2 газрыг боловсролын байгууллагын зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Булган аймгийн 6 дугаар цэцэрлэгтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3.Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшиж, ашиглахыг Булган аймгийн 6 дугаар цэцэрлэг (П.Оюунбилэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ